

УДК 398

DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-166-173

Монгол аман зохиол дахь гэрийн тотгоны дүрслэл (= Описание притолоки юрты в монгольском фольклоре)

*Заяасүрэн Ч.*¹

¹ Институт языка и литературы Академии наук Монголии (д. 54а, пр. Энхтайван, район Баянзурх, 13330 Улан-Батор, Монголия)
доктор филологии, научный сотрудник
E-mail: zayasuren_ch@yahoo.com

© КалмНЦ РАН, 2020

© Заяасүрэн Ч., 2020

Аннотация. В письменных памятниках, образцах монгольского фольклора (сказках, эпосе, загадках и др.) очень часто описывают притолоку двери юрты. В связи с этим в данной статье автор сделал попытку показать все описания дверной притолоки, которые встречаются в указанных образцах фольклора, и на основе анализа примеров дает разъяснение каждой примете и ритуалу (обряду). В дальнейшем на основе тщательного изучения каждого предмета и детали, из которых возводится монгольская юрта, ставшая важной составной частью культурного наследия монгольских народов, новые поколения получают возможность узнать их семантику и значение. Этому посвящена и данная статья.

Ключевые слова: монгольская юрта, притолока, символика, сказки, эпические сказания, загадки, образ, обряд

Благодарность. Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

Для цитирования: Заяасүрэн Ч. Монгол аман зохиол дахь гэрийн тотгоны дүрслэл (= Описание притолоки юрты в монгольском фольклоре) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 3. С. 166–173. (На монг.). DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-166-173

UDC 398

DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-166-173

The Description of Yurt Lintel in Mongolian Folklore

*Zayasuren Ch.*¹

¹Institute of Language and Literature of the Academy of Sciences of Mongolia (54a, Enkhtaivan ave., Bayanzurkh distr. Ulan Bator 13330, Mongolia)
Ph.D. (Philology), Research Associate
E-mail: zayasuren_ch@yahoo.com

© KalmSC RAS, 2020

© Zayasuren Ch., 2020

Abstract. In the written monuments, in the samples of Mongolian folklore (fairytales, epos, riddles, etc.) they often describe yurt lintel. In this article the author attempts to show all the descriptions of lintel that are mentioned in the Mongolian folklore and gives comments on each sign and rite based on the analysis of the examples. The thorough study of each object and detail in setting up a yurt that has become a significant constituent part of the cultural heritage of Mongolian nations will give the new generations the opportunity to learn their meaning and significance.

Keywords: Mongol yurt, lintel, symbolism, fairytales, epic legends, riddles, image, rite

Acknowledgement. The article was presented at the international scientific online conference «Mongolian Studies at the beginning of the 21st century: Current State and Development Prospects — II», held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

For citation: Zayasuren Ch. The Description of Yurt Lintel in Mongolian Folklore. In: *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 3. Pp. 166–173. (In Mong.) DOI: 10.22162/2587-6503-2020-3-15-166-173

Монгол гэрийн тотго ч аман зохиолд зохих дүрслэлээ олсон, монголчуудын зан заншилд ул мөрөө үлдээсэн эд юм. Тотгоны унь

ихэвчлэн тав байна. Энэ нь арга билгийн зохист харьцааг илэрхийлж буй анхны аргын тоо тав гэж үзэх үзэлтэй холбоотой болов уу. Монголчууд уг унинуудыг тавьдаг тотгоны нүхийг таван тэнгэр хэмээн ихэд эрхэмлэн дээдэлдэг заншилтай байжээ. Энэ тухай монгол ардын оньсогод тотгоны тогтоолыг оньсголохдоо бавжуур хэмээн нэрлэж ирснээс харж болно.

Бавжуур дээр таван гэлэн (тотго) гэх энэ оньсогын адилтгал нь тотгоны унь сагалдаргагүй байдаг. Лам хүн гэлэн сахил сахихдаа үс гэзэг, сахлаа хусуулж, хувраг болдогтой зүйрлэн ийнхүү сонирхолтой оньсголжээ. Мөн бурхны шашны лам хувраг, тойн, тоймог толгойт бүхэн нь өөрөө зумарч унасан тухай домоглон ярьдаг.

«Монгол ардын баатарлаг тууль»-д: гэрийг магтсан хэсэгт тотгыг дүрсэлсэн дүрслэл цөөнгүй тохиолдож байгаа юм. Жишээлбэл,

«Бужин даваа хаан» туульд:

«...Тотго талд нь тогос гургуул

Тонголзуулан сийлээд

Элкэн талд нь элээ, ангир шувууг

Эргэн нисгэн сийлээд явна аа...» [НТЧТ 2010: 175] гэсэн бол,

«Наран хаан хүү» туульд:

«...Тотго талд нь тогос гургуул

Тонголзуулан сийлээд

Хатавч талдаа элээ, ангир шувууг

Эргэлдүүлэн нисгэж сийлээд...» [НТЧТ 2010: 371].

гэх мэтээр тотго, хатавчинд тогос гургуул, элээ, ангир гэх зэрэг тэнгэрийн шувууг сийлж, чимэглэн зурж дүрсэлсэн явдал нь нэг талаар тэнгэртэй адилтган бэлгэдэж үзэсэнтэй холбоотой. Уг амьтныг дүрслэхдээ *«тогос гургуулыг тонголзуулан сийлээд»* гэж түүнийг байнгын хөдөлгөөнт шинж байдлаар дүрсэлсэн нь ихээхэн сонирхол татаж байгаа юм. Энэ нь тогос шувууг «эрт цагаас үхэлгүй мөнхийн бэлгэдэл хэмээн үзэж, өдөөр нь тэнгэр одыг бэлгэддэг. түүний өдийг “нүдтэй” хэмээн хэлэлцдэгтэй холбоотой» [Батбаяр 2013: 21] ажээ. Эндээс харахад сонор сэрэмжит байдал, гэр доторхыг хамгаалахын бэлгэдэл болгож тогос гургуул шувууны

дүр зургийг сийлбэрлэдэг байсан юм биш биз гэсэн санааг хэлж болмоор санагдана. Тотгоны тухай монгол ардын оньсогод:

— Тал дээр таван согоо...

— Таг дээр таван галуу...

— Тавцан дээр таван хүүхэд...

гэхчлэн хэлдэг нь дээрх санааг тодруулж өгч байна. «**Хаан чингэл тууль**»-д: «*Шөнө дундын хирд: Хар нүдэн Урангуа дагина нь хаан чингэл ахдаа тотгоор хоёр эрээн бор бялзуухай ороод ирсэн болж л зүүдэллээ гээд цочин тусан босож хэлэхээр нь дүүдээ ахыгаа байгаа цагт айж эмээх явдалгүй, унт гэв*» [МАБТ 1982: 77] хэмээжээ. Энэ нь Хар нүдэн Урангуа дагина мангаст баригдахынхаа урд шөнө гэрийн тотгоор эрээн бор бялзуухай орж ирж байгаагаар зүүдэлсэн нь бор бялзуухай ямар нэг муу зүйлийн зөн совинг дамжуулж байгаа мэдээч шувуу болохыг илтгэн харуулж байна. «Монгол гэрийн тотго, өрх, хатавч нь хий биет, хийсгэлэн дүртний орох гарах орон болдог» [Пагвадулам 2014: 58] тул Хар нүдэн Урангуа дагинын өстөн дайсан нь бялзуухай шувууны дүрд хувилан ирж шөнө орой түүнийг айлгаж ичээж байгаа нь Баатарлаг туулийн баатруудын өшөөт дайсан нь тэнгэрийн шувууны дүрд хувилж байгаагийн нэгэн тодорхой жишээ юм.

Тотготой холбоотой «**Монголын нууц товчоо**»-д «...шөнө бүр цагаан шар хүн өрх тотгоор гийгүүлэн орж ирээд миний хэвлийг илэхэд түүний гэрэл миний хэвэлд орж шингэх бүлгээ. тэр хүн гарах нар сарны хилээр шар нохой мэт шарвалзсаар гарч одно...» [МНТ 1990: 28] гэж Алунгуа эх хөвгүүддээ учрыг тайлбарлан өгч байгаагаар бичигдсэн байдаг. Уг өгүүлэмж ч өрх тотгоны зай бол хийсгэлэн хоосон биетний орж гарах орон гэдгийг бататгаж байгаа юм. Мөн нөгөөтэйгүүр гэрийн тотго нь монгол ардын аман зохиолд гэрийн доторх, гадаах байдлыг урьдчилан мэдэх, хэн нэгэнд мэдээ дамжуулах үүрэгтэйгээр дүрслэгдэж байна. Энэ тухай «**Өнчин охин**» үлгэрт: «...Нэг шөнө хүүгийн эх гадаа гарч явтал хүүгийн гэрт ярилцах, инээлдэх шиг сонсогдсонд “ийм орой болтол унтахгүй, ямар хүнтэй ингэж ярьж байдаг юм бол” гэж бодоод сэмхэн очиж тотгоор нь шагайвал, хүү нь гоо үзэсгэлэнт охинтой хоёулаа бичгийнхээ ширээний дэргэд сууж, хөгжилтэй

ярилцаж байхыг үзээд “манай хүү, ямар хүний тэнгэрийн дагина мэт гоо хүүхэнтэй ингээж байдаг билээ. Энэ хавьд л лав байхгүй, үзэгдээгүй, танихгүй, охин байх юм” гэж бодоод гэртээ очиж өвгөндөө хэлжээ. Хүүгийн эцэг огтхон ч үнэмшидэггүй. Тэгээд дараагийн шөнө эцэг эх хоёр нь хүн унтсанаас хойно сэмхэн гарч хүүгийн гэрийн хаяанд очиж, тотгоор нь шагайвал нэг гоо үзэсгэлэнт охинтой хүү нь мөн л хамт бичгийнхээ ширээний дэргэд суугаад ярилцаж байжээ» [Содном 2018: 59] гэснээс гэр дэх бүх учрыг нууцаар мэдэхэд тотго гол үүрэг гүйцэтгэдэг болох нь тов тодорхой байгаа юм. Мөн монгол ардын «**Хятадын баригдаггүй хулгайч**» үлгэрт ч тотгоны дээрх үүрэг «*Ламбугай, чи урьдаар нэг туламд ороодох. би дараа нь туламд чинь оруулаад өгье*» гэж дуугараад буцаж эргэж хурч ирээд тотгоор нь шагайгаад харсанд, лам, дээлээ тайлаад туламд орох гэж байгаа бололтой байна гэнэ. Тэгэхлээр нь гэрт харайж ороод ламыг барьж аваад шар тосонд нь дүрж хаячхаад, гэр рүүгээ гүйсэн чинь зүв зүгээр таталдах ч юмгүй явжээ» [ГХҮТ 2008: 123] гэх мэтээр дүрслэгджээ.

Ер нь Монголчууд гэрийнхээ дээврийг үүдний тотгонд үл шүргүүлэн тааруулж барьдаг нь гэрийн доторх болон гадаах үйл явцыг харах, хий хийсгэлэн биет чөлөөтэй зорчих бололцоог олгож өгсөн нь дээрх түүхэн сурвалж болон монгол ардын үлгэр, туулийн дүр дүрслэлээс тов тодорхой харагдаж байгаа юм. Мөн монголчууд гэрийнхээ «үүд хаалгыг ихэд эрхэмлэн дээдэлдэг, ялангуяа тотгыг өрх гэрийн үндэс, дэлгэрэхийн бэлгэдэл болгодог» [Баттогтох 2011: 107] байжээ. Тиймээс ч тотготой холбогдох цөөнгүй зан үйл бидний үед уламжлагдан иржээ. Тухайлбал, Монголчуудын мал сүрэг, амь амьдралаа тэнгэр бурхан, газар усны эзэд, заяагч нарт даатгахын тулд хийдэг олон янзын домын арга хийдэг. Жишээ нь: Малчид тотгоны униндаа хөрөөгөө хавчуулахдаа ирийг нь гадагш харуулан хавчуулдаг. Энэ нь гаднаас орж ирэх элдэв муу муухай зүйлээс хамгаалан домнож байгаа зан үйл. Мөн мал сүрэг нь хөдөө хээр хонох үед гэрийн эзэн галын хайчны амыг хонины ноосоор ороож боогоод тотгонд хавчуулдаг заншилтай. Энэ нь араатны амыг хааж боож, малаа хамгаалж байгаа хэрэг юм.

Зарим нутагт зуны эхэн сард төл малаа хөнгөлөөд тотгоны унь дээгүүр харайлгаж домнодог. Ийнхүү монголчууд хамгийн эрхэмлэн дээдэлдэг тотгоны унины дээгүүр харайлгадаг нь ямар нэгэн өвчин эмгэг тусалгүй хурдан түргэн эдгэрэхийг зөгнөн бэлгэдэж байгаагийн нэг илрэл мөн. Тотготой холбоотой хорио цээрийн ёс ч цөөнгүй байгаагийн нэг нь тотгоноос дүүжлэгдэхийг үл таашаадаг. учир нь боож үхэх хүн тотгоноос дүүжлэгддэг гэх аман яриа бий.

Түүхэн сурвалж бичиг, аман зохиолын эх хэрэглэгдэхүүн, өмнөх судлаачдын судалгааны бүтээл, зан заншилд тусгагдаж буй мэдээ баримтаас үзэхэд ч тотгыг маш эртнээс эрхэмлэн дээдэлж иржээ. Үүний жишээ нь: Алтайн Урианхайчууд битүүний орой гэрийнхээ тотго, хатавчны баруун бүсэнд мөс цас тавихдаа цагаан өвгөнд зориулдаг. цагаан өвгөн бол монголчуудын дунд ихэд дэлгэрсэн шүтээний нэг. Тиймээс «*цастын цагаан өвгөн*» жил бүрийн битүүний орой айл айлаар явж амьдрал ахуйтай нь танилцдаг гэж үздэг. Ийм учраас энэ өдөр айл бүр цагаан өвгөнийг цас мөсөн замаар, таягаа тулан залран ирэх зам мөрийг зааж туслан авч, хүндэтгэн зочлох бэлгэдлийн утга санааг илэрхийлдэг байна. Түүнийг тэр үдэш баярлуулахын тулд цай унд, идээ шүүс элбэг бэлтгэж ахмадуудаасаа эхлэн хот айл, ахан дүүсээ ихэд хүндэтгэн дайлах ёстой гэж үздэг. Ингэснээр цагаан өвгөнийхөө ивээлд сайхан амьдарна хэмээн бэлгэддэг үзэл ойлголт байв. Монголын цагаан сарын битүүний үдэш айл өрхүүд тотгоны баруун дээр гурван ширхэг цэвэр тунгалаг мөс, будаа тавьдаг учиртай. Мөс нь Лхам бурхны хүлгийн ундаа, будаа нь Бурхан тахилдаа өргөж байгаа идээ тахилын дээж юм. Мөн гэрийнхээ тотгоны зүүн дээр улаан харгана тавьж, бод малын чөмөгт яс чанаж идээд хага цохидог нь муу муухай бүхнийг хааж хөөхийг зөгнөн бэлгэдэж буй нэгэн ёсны домын үйл. Эдгээр ёс заншил нь эртний монголчуудын байгаль дэлхий, уул усаа амьдчилан шүтэх үзэл, хүн байгалийн хоорондын зохицон амьдрахуйн уламжлалт сэтгэлгээний илэрхийлэл юм. Нийт монголчуудын үзэл ойлголтоор бол «Лхам бурхан хүнд сайн сайхныг авчрах гэж шинийн нэгний өглөө яарч явахад нь шулам саад хийдэг тул шулмын унааны хөлийг хугалж буй» юм [Дулам

2018: 13]. Монгол ардын аман зохиол, зан заншилд тогтоны талаар туссаныг товч дурдахад ийм байна.

ДҮГНЭЛТ

Монгол аман зохиол, сурвалж бичиг, зан заншилд тогтоотой холбоотой дүрслэгдэхүүн цөөнгүй байна. Жишээлбэл, сурвалж бичиг, монгол ардын үлгэр, туульд тогто нь гэр доторх болон гадаахыг урьдчилан мэдэх, хий хийсгэлэн биетэн дамжин орох гол үүрэгтэйгээр дүрслэгдэж байгаа юм. Мөн монгол туульд тогто нь сайн сайхан, мөнхөд үргэлжлэх бэлгэдэл болж байгаа бол зан заншилд тогто бол шүтэн бишрэх гол объектын үүрэгтэйгээр дүрслэгдэж байна.

Монгол домын зан үйлд алив муу муухай бүхнийг хааж, зайлуулах гол хэрэглэгдэхүүн болж байна. Харин тогтог нь оньсогод дүрсэлснийг бүхэлд нь ажиглахад бодит юмсын адил төстэй талыг шууд адилтгаж дүрсэлсэн явдал нь монгол хүний танин мэдэх сэтгэлгээнд үндэслэгдэн бүтсэн гэдэг нь харагдаж байна.

Ингэж манай ард түмэн аман зохиол, зан заншлаар дамжуулан аливаа зүйлийн утга учир, бэлгэдэлт чанар, зан заншлыг үр хүүхэд, хойч үедээ ойлгуулж, танин мэдүүлдэг байсан нь дээрхээс тодорхой харагдаж байна.

Ер нь цаашид ганц тогто биш монголчуудын өв соёлын нэгэн хэсэг болсон монгол гэрийг бүрэлдүүлж байгаа эд зүйл болгоныг нарийвчлан судалж, учир зүйг залуу хойч үеийнхэнд таниулж мэдүүлэх нь даяаршил дэлхий дахиныг хамарч буй өнөө цагт ач холбогдолтой гэж үзэж байна.

Ном зүй

Баатархүү, Одсүрэн 2015 — *Баатархүү Б., Одсүрэн Д.* «Монгол гэр» тайлбар толь. Хянан нягталсан: Академич Ж. Болдбаатар. Улаанбаатар: «ADMON ПРИНТ» ХХК, 2015.

Батбаяр 2013 — *Батбаяр Д.* Бүтээхүйн зүй тогтол / ред. Б. Өөлүүн. Улаанбаатар: «Соёмбо принтинг» ХХК, 2013. 234 х.

Баттогтох 2011 — *Баттогтох Д.* Монгол гэрийн утга соёлын нэрийгтгэл тайллага. Ариутган шүүгч Г. Гантогтох. Улаанбаатар: «Соёмбо принтинг» ХХК, 2011.

- ГХУТ 2008 — Гонгорын хэлсэн үлгэр, туульс / Эмхэтгэн боловсруулж, өмнөх үг, удиртгал, тайлбар бичсэн Т. Баясгалан. Ред. П. Хорлоо. Улаанбаатар: ШУА-ийн Хэл зохиолын хурээлэн, 2008. 253 х.
- Дулам 2018 — *Дулам С.* Бэлгэдэл зүйн судалгаа. Эрдэм шинжилгээний өгүүлэл-1(IV). Улаанбаатар, 2018.
- Дулам С. 2011 — Монгол бэлгэдэл зүй-IV (Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй). Нэмэн засварласан гурав дахь хэвлэл. Ариутган шүүсэн Д. Бум-Очир. Улаанбаатар, 2011.
- МАБТ 1982 — Монгол ардын баатарлаг тууль. Эмхэтгэж, эрдэм шинжилгээний удиртгал бичсэн Ж. Цолоо / ред. Х. Сампилдэндэв. УХГ. Улаанбаатар, 1982. Х. 165.
- МНТ 1990 — Монголын нууц товчоо. Улаанбаатар, 1990. 960 с.
- НТЧТ 2010 — Нэрт туульч Чойсүрэнгийн туульс. Эмхэтгэн боловсруулж, эрдэм шинжилгээний удиртгал бичсэн Б. Катуу. Ариутган шүүсэн Д. Цэрэнсодном. «Shingyorins» хэвлэх үйлдвэрт эхийг бэлтгэж хэвлэв. Улаанбаатар, 2010. Х. 786.
- Пагвадулам 2014 — *Пагмадулам М.* Хүүхэн хутагтын түүх домог, түүхэн дуу / ред. Дулам С. Цэдэв Д. Улаанбаатар: «БЭМБИ» ХХК, 2014. 194 х.
- Содном 2018 — *Содном Б.* Аман зохиол. Эмхэтгэж, хэвлэлд бэлтгэсэн Ч. Заяасүрэн, Г. Батмөнх. Өмнөх үг бичиж, редакторласан профессор Д. Цэдэв. Улаанбаатар, 2018.